



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас/Факс: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2024.01.03 № 1/18
танай _____-ны № _____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу УНТЭ-ийн 2023 оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 24 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ХИШИГЖАРГАЛ

000007

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН						
УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ						
Д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр,огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ						
1	11.6	Статистикийн тухай	11.6. Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна.	УНТЭ-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн "Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дүрэм, бүтэц, орон тоо, стратеги төлөвлөгөө батлах тухай" 07 тоот тогтоолоор Эмнэлзүйн эрхэлсэн дэд захирлын удирдлага дор Эмнэлзүйн албаны харъяа статистикийн нэгжтэй байна гэж заасан. Статистикийн нэгж нь 1 их эмч, 2 бага эмчийн орон тоотой ажилла байна. Статистикийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмыг удирдлага болгон эмнэлгийн статистик, мэдээллийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, эмнэлгийн үйл ажиллагааны холбогдох үнэн зөв, бодитой мэдээллийг эрх бүхий байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.	100%	Хэрэгжүүлж ажилласан
2	55.3	Төрийн албаны тухай	55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	УНТЭ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 05 дугаар 29-ний өдрийн 07 тоот тогтоолоор “УНТЭ-ийн дүрэм, бүтэц, орон тоо, стратеги төлөвлөгөө”-г баталсан. Уг батлагдсан 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний тэргүүлэх стратегиар “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан. <i>Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтот дэд 4 хөтөлбөрүүдтэй.</i> Үүнд: ➤ Технологид суурилсан хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр ➤ Ажилчдын ур чадварыг хөгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр ➤ Хувь хүний хөгжлийн хөтөлбөр ➤ Олон улсын ажлын байрны жишигт нийцсэн ажилтны сургалт, хөгжлийн хөтөлбөр	100%	Хэрэгжүүлж ажилласан

				Стратеги төлөвлөлтийн дагуу Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө батлагдсан. Уг мастер төлөвлөгөөг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлж ажиллаж байна. 1. Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотой эмнэлгийн ерөнхий захирлын 2022.04.29-ний өдрийн А/135 тоот тушаалаар “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ”-г шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. 2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/01 тоот тушаалаар “Ажилтан хөгжүүлэх хөтөлбөр”-ийг, мөн захирлын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/44 тоот тушаалаар “Шинэ ажилтныг чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөр”-ийг тус тус баталсан. Уг хөтөлбөрүүд нь Улсын нэгдүгээр төв эмнэлгийн шинэ ажилтныг байгууллагатай танилцуулах, заавал мэдэх багц мэдлэгийг эзэмшүүлэх, мэдлэг, ур чадвар, хандлагатай мэргэшсэн ажилтанг бүрдүүлэх зорилготой юм. Дээрх стратеги, дүрэм, журмуудын дагуу ажилтнуудын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг ханган ажиллаж байна. 2023 онд УНТЭ нь Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа буюу мөнгөн урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, хоол унаа, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, давтан суралцах, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, сургалт хөгжил, нормын хувцас зэрэгт нийт 7.8 тэрбум төгрөг зарцуулсан байна.		
--	--	--	--	---	--	--

3	29.2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай	“29.2.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарах бүрд Засгийн газраас тогтоосон журмын дагуу осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэх үүрэгтэй бөгөөд осол, хурц хордлогын шалтгааныг тогтоох акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулна.”	УНТЭ-ийн ерөнхий захирлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/144 тоот тушаалаар “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс”-ыг шинэчлэн байгуулсан. 2023 оны 12 сард ХАБЭА-н ажилтан нь сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий “ХАБ Академи” байгууллагатай хамтран удирдах ажилтны мэдлэг олгох ХАБЭА-н сургалтыг зохион байгуулж нийт 40 гаруй удирдах ажилтнуудыг хамруулсан бөгөөд тус сургалтанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг ажиллах дүрэм, зарчмыг танилцуулсан.	90%	Хэрэгжүүлж ажилласан
4	27.1 27.2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай	27.1. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна. 27.2. Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.	1. 2023.04.15-ны өдөр эмнэлэгт ХАБЭА хариуцсан ажилтныг гэрээгээр ажиллуулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж шалгарсан иргэн Ж.Урантөгстэй Хөлсөөр ажиллах гэрээ байгуулан 2023.04.17-ны өдрөөс эмнэлгийн ХАБЭА-н ажлыг хариуцуулж, гэрээний үүргийг гүйцэтгүүлж байна. 2. ХАБЭА хариуцсан ажилтан Ж.Урантөгс нь томилогдсон хугацаанаасаа хойш эмнэлгийн хэмжээнд ажлын байран дахь ХАБЭА-н сургалтыг 8 удаа зохион байгуулж 317 ажилтныг хамруулсан. 3. 2023 оны 12 сард сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий “ХАБ Академи” байгууллагатай хамтран удирдах ажилтны мэдлэг олгох ХАБЭА-н сургалтыг зохион байгуулж нийт 40 гаруй удирдах ажилтнуудыг хамруулсан. 4. Мөн ХАБЭА хариуцсан ажилтан Ж.Урантөгс нь томилогдсон хугацаанаасаа хойш ХАБЭМТ, Монголын цацрагийн хамгаалалтын нийгэмлэгээс зохион байгуулсан ХАБЭА-н ажилтнуудыг хамруулсан 4 удаагийн сургалт,	100%	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг ажлыг хариуцсан ажилтантай болсон бөгөөд удирдлага, зохион байгуулалтыг хариуцах Комисс, зөвлөлийг шинэчлэн байгуулсан

				уулзалтанд хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн. 5. Байгууллагын 2023-2026 онд үйлчлэх Хамтын гэрээг шинэчлэн байгуулж Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хамтын гэрээнд ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах талаар Ажил олгогч болон эмнэлгийн дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн салбар хороо хамтран хариуцах үүргийг нэг бүлэг болгон тусгаж, хэрэгжилтийг хангах ажлыг эхлүүлээд байна. 6. Эмнэлгийн ерөнхий захирлын 2022.04.29-ний өдрийн А/135 тоот тушаалаар “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ”-г шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Дотоод хэм хэмжээний долдугаар зүйлд хамтын гэрээгээр зохицуулах харилцаа, зарчмыг бүрэн тусгасан. 7. УНТЭ-ийн ерөнхий захирлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/143 тоот тушаалаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл”-ийг шинэчлэн байгуулсан.		
5	27.3.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай	27.3.1.аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх;	УНТЭ-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод журам"-ын зарим нэг заалтыг ХАБЭА-н хуулийн заалтын дагуу шинэчлэн өөрчлөлт хийж батлуулсан.	85%	5 журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ажил хийгдсэн.

6	38.1	Хөдөлмөрийн тухай	38.1.Хамтын гэрээг ажил олгогчийн төлөөлөгчид болон үйлдвэрчний эвлэл, хэрэв ийм байгууллага байхгүй бол нийт ажилтны хурлаас сонгогдсон ажилтны төлөөлөгчид байгуулна.	УНТЭ-ийн Захиргаа болон ҮЭХ-ны тэргүүлэгчид хамтран шинэчлэн байгуулах хамтын гэрээг шинээр байгуулах, батлуулах ажлыг Хөдөлмөрийн тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулсан. Эмнэлгийн дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооноос ирүүлсэн санаачлагыг Ажил олгогч хүлээн авч эмнэлгийн ажлын хэсэг байгуулан ажиллуулж хэлэлцээний журмаар гэрээний нөхцөлийг харилцан тохиролцож гэрээг байгуулан нийслэлийн Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст 2023.04.14-ний өдөр бүртгүүлж баталгаажуулсан. УНТЭ-ийн хамтын гэрээг баталгаажсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжүүлж ажиллаж байна. Хамтын гэрээнд ажилтны цалин хөлс, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийн баталгааг хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, мэргэшүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэх зэрэг хуулиар шууд зохицуулаагүй бөгөөд ажилтны хөдөлмөрлөх эрхийг хангаж, хамгаалахад чиглэсэн асуудлуудыг тусгасан.	100%	Хамтын гэрээг батлуулан хэрэгжүүлж байна
7	21	Эрүүл мэндийн тухай хууль	21.1.Эрүүл мэндийн байгууллага дүрэмтэй байна. 21.2.Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	УНТЭ нь Эрүүл мэндийн сайдын 2019.07.29-ний өдрийн А/368 тоот тушаалаар батлагдсан “УНТЭ-ийн дүрэм”-ийг мөрдөн ажиллаж байна. УНТЭ нь 2019 онд Төлөөлөн удирдах зөвлөлтэй болж, гүйцэтгэх захирлыг Төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллуулах болсон гэх зэрэг удирдлагын тогтолцоонд зарчмын шинжтэй өөрчлөлт орсон боловч эмнэлгийн дүрэмд тусгагдаагүй байсан, Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөл эмнэлгийн зохион байгуулалтын бүтцийг батлах зэрэг өөрчлөлт,	100%	Тус эмнэлэг дүрмийн төслөө шинэчлэн боловсруулж ЭМЯ-нд хүргүүлсэн

			21.3.Эрүүл мэндийн байгууллагын дүрэмд дараах зүйлийг тусгана: 21.3.1.байгууллагын үндсэн зорилго, чиг үүрэг; 21.3.2.удирдах бүрэлдэхүүн, түүний эрх хэмжээ; 21.3.3.санхүүжилтийн эх үүсвэр; 21.3.4.хөрөнгийн зарцуулалт.	шинэчлэлтүүдийг эмнэлгийн дүрэмд тусган шинэчлэх шаардлагатай болсон. Иймд Ерөнхий захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дүрэм”-ийг шинчлэн дүрмийн бүтэц, агуулгыг Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт нийцүүлэн боловсруулж 2023 оны 05 дугаар сард Эрүүл мэндийн яаманд цахим болон цаасан хувилбараар тус тус хүргүүлсэн.		
8	17.7	Эрүүл мэндийн тухай хууль	17.7.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүн, тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүн, олон нийтийг төлөөлөх гурван гишүүнтэй байна. 17.8.1.эмнэлгийн өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүнийг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус бүр нэг хүнийг нэр дэвшүүлснээр;	Эмнэлгийн сувилагч,тусгай мэргэжилтэн, эмнэлгийн мэргэжилтнээс бусад ажилтныг төлөөлөн эмнэлгийн төлөөлөн удрдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан 2 гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбоотойгоор Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын баталсан удирдамжийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон ажиллагааг Эрүүл мэндийн яамны төлөөлөгчидтэй хамтран зохион байгуулав. Эмнэлгийн Ерөнхий захирлын тушаалаар сонгуулийг зохион байгуулах бэлтгэх ажлыг хангах ажлын хэсгийг байгуулж ажиллуулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох сонгуулийг 2023 оны 05 дугаар сард зохион байгуулж сувилагч,тусгай мэргэжилтнийг төлөөлөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасгийн сувилагч, эмнэлгийн мэргэжилтнээс бусад ажилтны төлөөлөгчөөр Эмнэлгийн хэрэгсэл,аж ахуй,үйлчилгээ, хангамж,түгээлтийн албаны дарга нар сонгогдсон. Хурлын үйл ажиллагаа хэвийн явагдсан бөгөөд аливаа маргаан, хууль тогтоомж зөрчсөн асуудал гараагүй байна.	100%	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2 гишүүний сонгуулийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан

9	20.2.3.	Эрүүл мэндийн тухай хууль	20.2.3.үйл ажиллагаандаа чанарын стандартын шаардлагыг хангах УНТЭ-т үйл ажиллагаандаа мөрдлөг болгож чанарын стандартын шаардлагыг хангах УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2019 оны 02.15-ны А/44 тоот “Эмнэлзүйн стандарт, удирдамж технологийн жагсаалт батлах тухай” тушаалыг мөрдөж ажиллаж байна. Нийт 306 стандарт заавар удирдамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 оноос стандарт зааварын жагсаалтыг шинэчлэн нийт 344 жагсаалт гаргасан ерөнхий захирлын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. 2023 онд өвчний түүх бичилт, стандарт заавар удирдамжын хэрэгжилтийн хувь 92,5%-тай байна. УНТЭ-д мөрдөж буй стандарт заавар, удирдамж жагсаалт <table><tr><th>Багц</th><th></th></tr><tr><td>Үндсэн стандарт</td><td>6</td></tr><tr><td>Чанарын удирдлага, эрсдэл</td><td>9</td></tr><tr><td>Хүний нөөцийн удирдлага</td><td>6</td></tr><tr><td>Эм хангамж</td><td>3</td></tr><tr><td>Халдвараас сэргийлэлт тандалт, орчны эрүүл ахуй</td><td>6</td></tr><tr><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал</td><td>5</td></tr><tr><td>Клиник лаборатори, эд эс судлал</td><td>17</td></tr><tr><td>Үйл оношийн шинжилгээ</td><td>21</td></tr><tr><td>Шинжилгэний дүгнэлт бичих</td><td>9</td></tr><tr><td>Цөмийн онош зүй, оношилгоо, эмилгээний үйлдэл /ДОТ/</td><td>11</td></tr><tr><td>Бөөрний эмгэг судлал</td><td>10</td></tr><tr><td>Хоол боловсруулах эрхтэн судлал</td><td>11</td></tr><tr><td>Эрхтэн шилжүүлэн суулгах</td><td>5</td></tr><tr><td>Зүрхний эмгэг судлал</td><td>7</td></tr><tr><td>Уушгины эмгэг судлал</td><td>7</td></tr></table>	Багц		Үндсэн стандарт	6	Чанарын удирдлага, эрсдэл	9	Хүний нөөцийн удирдлага	6	Эм хангамж	3	Халдвараас сэргийлэлт тандалт, орчны эрүүл ахуй	6	Хөдөлмөрийн аюулгүй байдал	5	Клиник лаборатори, эд эс судлал	17	Үйл оношийн шинжилгээ	21	Шинжилгэний дүгнэлт бичих	9	Цөмийн онош зүй, оношилгоо, эмилгээний үйлдэл /ДОТ/	11	Бөөрний эмгэг судлал	10	Хоол боловсруулах эрхтэн судлал	11	Эрхтэн шилжүүлэн суулгах	5	Зүрхний эмгэг судлал	7	Уушгины эмгэг судлал	7	93.8%	3 эмнэлзүйн заавар боловсруулах шатандаа байна
Багц																																					
Үндсэн стандарт	6																																				
Чанарын удирдлага, эрсдэл	9																																				
Хүний нөөцийн удирдлага	6																																				
Эм хангамж	3																																				
Халдвараас сэргийлэлт тандалт, орчны эрүүл ахуй	6																																				
Хөдөлмөрийн аюулгүй байдал	5																																				
Клиник лаборатори, эд эс судлал	17																																				
Үйл оношийн шинжилгээ	21																																				
Шинжилгэний дүгнэлт бичих	9																																				
Цөмийн онош зүй, оношилгоо, эмилгээний үйлдэл /ДОТ/	11																																				
Бөөрний эмгэг судлал	10																																				
Хоол боловсруулах эрхтэн судлал	11																																				
Эрхтэн шилжүүлэн суулгах	5																																				
Зүрхний эмгэг судлал	7																																				
Уушгины эмгэг судлал	7																																				

				<table><tr><td>Дотоод шүүрэл судлал</td><td>5</td></tr><tr><td>Хэрх-Үе судлал</td><td>5</td></tr><tr><td>Үений мэс засал</td><td>2</td></tr><tr><td>Цусны эмгэг судлал</td><td>13</td></tr><tr><td>Бүдүүн шулуун гэдэсний мэс засал</td><td>3</td></tr><tr><td>Чих хамар хоолойн мэс засал</td><td>13</td></tr><tr><td>Шүд, Эрүү нүүрний мэс засал</td><td>16</td></tr><tr><td>Бөөрний мэс засал</td><td>5</td></tr><tr><td>Ерөнхий мэс засал</td><td>16</td></tr><tr><td>Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж</td><td>7</td></tr><tr><td>Мэдээгүйжүүлэг</td><td>6</td></tr><tr><td>Нүдний мэс засал</td><td>8</td></tr><tr><td>Мэдрэлийн эмгэг судлал</td><td>10</td></tr><tr><td>Уламжлалт,нөхөн сэргээх засал</td><td>12</td></tr><tr><td>Хавдрын оношилгоо, эмчилгээ</td><td>14</td></tr><tr><td>Сувилахуйн удирдамж</td><td>31</td></tr><tr><td>Нийт</td><td>306</td></tr><tr><td>Стандарт</td><td>214</td></tr><tr><td>Удирдамж/ Заавар</td><td>92</td></tr></table>	Дотоод шүүрэл судлал	5	Хэрх-Үе судлал	5	Үений мэс засал	2	Цусны эмгэг судлал	13	Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	3	Чих хамар хоолойн мэс засал	13	Шүд, Эрүү нүүрний мэс засал	16	Бөөрний мэс засал	5	Ерөнхий мэс засал	16	Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж	7	Мэдээгүйжүүлэг	6	Нүдний мэс засал	8	Мэдрэлийн эмгэг судлал	10	Уламжлалт,нөхөн сэргээх засал	12	Хавдрын оношилгоо, эмчилгээ	14	Сувилахуйн удирдамж	31	Нийт	306	Стандарт	214	Удирдамж/ Заавар	92		
Дотоод шүүрэл судлал	5																																											
Хэрх-Үе судлал	5																																											
Үений мэс засал	2																																											
Цусны эмгэг судлал	13																																											
Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	3																																											
Чих хамар хоолойн мэс засал	13																																											
Шүд, Эрүү нүүрний мэс засал	16																																											
Бөөрний мэс засал	5																																											
Ерөнхий мэс засал	16																																											
Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж	7																																											
Мэдээгүйжүүлэг	6																																											
Нүдний мэс засал	8																																											
Мэдрэлийн эмгэг судлал	10																																											
Уламжлалт,нөхөн сэргээх засал	12																																											
Хавдрын оношилгоо, эмчилгээ	14																																											
Сувилахуйн удирдамж	31																																											
Нийт	306																																											
Стандарт	214																																											
Удирдамж/ Заавар	92																																											
ЭМС-ын 2022 оны А/346 тоот тушаалын дагуу Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг нийтлэг болон өвөрмөц үзүүлэлтээр тооцон ажиллаж байна. ЭМС-ын 2022 оны А/464 тоот тушаалаар шинэчлэн боловсруулах стандарт, эмнэлзүйн зааварын жагсаалт ирсэний дагуу УНТЭ-д 3 эмнэлзүйн заавар стандарт боловсруулалтын шатанд явж байна.																																												

10	20.2.5	Эрүүл мэндийн тухай хууль	20.2.5. Хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах	1.Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачлан хэрэгжүүлж буй гурван тулгуурт үндэсний хөдөлгөөний нэг болох “Эрүүл монгол хүн” сэдэвт аяны хүрээнд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Эрүүл Монгол Хүн Үндэсний Фестиваль”-д УНТЭ оролцож олон нийтийг эрүүл амьдралын зан үйл, идэвхитэй дасгал хөдөлгөөнд уриалах, нийтийн эрүүл мэндийн тусламжийг өргөжүүлэх зорилгын талаар ард иргэдэд мэдээлэл өгч, үзлэг оношилгоо хийх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулсан. УНТЭ-ийн ДШСДТ-ийн эмч сувилагч нар хамтран өдөрлөгт оролцсон 400 гаруй иргэний цусан дахь сахарыг түргэвчилсэн тестеер тодорхойлж 30 гаруй иргэний далд сахарыг оношилж илрүүлж чихрийн шижин өвчний үеийн эмчилгээ, урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. НЭМА-ны хоолзүйч 150 гаруй иргэнд чихрийн шижин өвчний үеийн хооллолт, хоол эмчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Мөн ажлын байрны хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд СЗЭТ-ийн хөдөлгөөн засалч нар ямар ч орчин нөхцөлд хийж болох дасгал хөдөлгөөнийг оролцсон иргэдэд зааж хэвшүүлсэн. 2.УНТЭ-ийн НЭМА нь ЭМЯ-тай хамтран “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд ард иргэдэд таргалалтаас үүсэх хор уршиг, таргалалтын урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл олгох богино хэмжээний зөвлөгөөний контентод оролцсон бөгөөд уг контент цахим орчинд байршиснаас хойш нийтдээ 18700 гаруй үзэлтийн хандалт авсан байна. 3.2023 оны 03 сард УНТЭ-ийн Амбулатороор үйлчлүүлж буй үйлчлүүлэгч болон тэдний ар гэрт	100%	Хэрэгжүүлж ажилласан
----	--------	---------------------------	---	--	------	----------------------

				зориулан бөөрний өвчний үеийн хооллолт, хоол эмчилгээ, илчлэг тооцох арга, илчлэг гэж юу вэ? эрүүл бус хүнсний хэрэглээний талаар мэдээлэл олгох өдөрлөгийг ЭХЭМҮТ, ШУТИС-ийн харьяа шим тэжээл судлалын төвийн хоолзүйч нартай хамтран зохион байгуулан ажилласан уг өдөрлөгт 60 гаруй амбулатороор үйлчлүүлсэн үйлчлүүлэгч хамрагдсан бөгөөд бөгөөд УНТЭ-ийн Бөөрний төвд хэвтэн эмчлүүлж буй 10 гаруй эмчлүүлэгчдэд сургалт зөвлөгөө өгч Inbody биеийн найрлага хэмжигч аппаратаар хэмжилт хийж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. 4.УНТЭ-ийн сувилагчийн ажлын байрыг шинэ төгсөгчдөд сурталчлах ажил олгогчийн уулзалт, өдөрлөгийг 2023 оны 04 сарын 07-ний өдөр зохион байгуулсан бөгөөд тус өдөрлөгийн хүрээнд ЭМЯ-наас хэрэгжүүлж буй “Энэ жилдээ эрүүл жиндээ” аянд нэгдэж нийт оюутнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан бөгөөд АШУҮИС-ийн 150 гаруй оюутнуудад эрүүл идэвхтэй амьдралыг сурталчлах, эрүүл зан үйл, эрүүл зөв хооллолтын талаарх мэдлэг, хандлага, ойлголт сайжруулах зөвлөмж өгч 80 гаруй оюутныг Inbody биеийн бүтэц найрлагын аппарат дээр хэмжилт хийж тухайн оюутан бүрт тохирсон илчлэгийг тооцсон хооллолтын зөвлөмжийг өгсөн. 5.НЭМА-ны хоолзүйч Э.Санчир нь хүн амд зохистой хооллолт, эрүүл зөв хооллолтын дадлын тухай эрүүл мэндийн боловсрол олгох зөвлөгөө, мэдээллийг 2023 оны 02 сарын 15-ны өдөр С1 телевизийн оройн мэдээний зочны цаг буланд оролцож мэдээлэл олгосон.		
--	--	--	--	---	--	--

11	20.2.7	Эрүүл мэндийн тухай хууль	20.2.7.эмнэлгийн мэргэжилтэнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	УНТЭ-ийн ерөнхий захирлын 2023.02.16-ны өдрийн А/51 тоот тушаалаар “УНТЭ-ийн хүний нөөцийн сургалт, хөгжлийн журам”-ыг баталж мөрдөн ажиллаж байна. 2023 онд нийт 130 ажилтанг гадаад улсад урт богино хугацааны сургалт, хуралд хамрагдсан байна. Ажилтнуудын гадаад сургалтыг улсаар нь задалбал Австри улсад-4, Австрали-3, АНУ-7, Араб-2, Казакстан-1, БНСУ-63, Турк-3, БНХАУ-5, Малайз-1, Тайван-19, Тайланд-3, Филиппин-2, Герман-3, Япон улсад-13, Испани-1, Канад улсад-1 ажилтан тус тус гадаад сургалтад хамрагдсан байна. Эрдмийн зэрэг ахиулсан ажилтнуудын мэдээлэл 2023 онд УНТЭ-ийн Гастроэнтерологийн төвийн их эмч Б.Сумъяа, ЕМЗТ-ийн их эмч С.Түдэвдорж, ЭЭТ-ийн их эмч Б.Мөнхсайхан нар АУ-ны магистрын зэрэг, ХҮСҮСТ-ийн ахлах сувилагч Д.Жимсээ Сувилахуйн магистрын зэрэг тус тус амжилттай хамгаалсан. Ажилтнуудыг эрдмийн зэрэг ахиулах урьдчилан болон жинхэнэ хамгаалах шалгалтад ороход дэмжлэг үзүүлж цалинтай чөлөөг тухай бүрт олгож ажилласан. УНТЭ болон АШУҮИС-ийн хамтын ажиллагааны гэрээний дагуу 2022-2023 оны хичээлийн жилд суралцаж буй 7 магистрант 4 докторант буюу УНТЭ-ийн 11 эмч, ажилтны сургалтын төлбөрт 15% хөнгөлөлт үзүүлсэн. Төгсөлтийн дараах сургалтад 2023 онд 55 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.	100%	Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллаж байна
12	45.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил		1. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтлан ажиллаж байна. 2. Байгууллагын худалдан авах ажиллагааны	100%	Худалдан авалтын үйл ажиллагаанд хууль тогтоомж зөрчсөн

		үйлчилгээ худалдан авах тухай	45.1.Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.	төлөвлөлт, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалт, тендер сонгон шалгаруулалт болон бусад журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбогдох бүх мэдээллийг ил тод мэдээлнэ. 3. Тендерийн үнэлгээний хороо нь худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, бодлогын баримт бичиг, хэрэглэгчийн сэтгэл ханамж, захиалагчийн шаардлагыг хангасан байх зарчмыг баримталж, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудад заасан зарчим, ил тод байдлын шалгуурыг ханган ажиллах үүрэг хүлээнэ. 4. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалт явуулах тухай болон тендерийн төлөвлөгөө, урилга, тендер шалгаруулалтын үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж цахим хуудас www.tender.gov.mn сайтын үйл ажиллагааг цаг тухай бүр хөтлөн явуулж байна.		зөрчил,дутагд ал гараагүй байна
13	16	Төсвийн тухай	16.5.Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.6.дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; 16.5.7.байгууллагын санхүүгийн болон төсвийн	16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; УНТЭ нь 2023 оны төсвийн төслийг ТУЗ-ийн хуралд танилцуулж батлуулан 2023 онд 102,3 тэрбум төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн тус онд 59,1 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. 2022 оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад 2023 оны төсөв нь 20 орчим хувиар өссөн байна. Энэ өсөлт нь нийт ажилтны цалин болон тусламж	100%	Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөж байгаа бөгөөд төсвийн тухай хуулийг зөрчсөн асуудал гараагүй байна

			гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах; 16.5.8.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх.	үйлчилгээний эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, багаж, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээний төсөв нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд ажилтнуудын ажлын бүтээмж дээшлэх, тусламж үйлчилгээний чанар нэмэгдэх, ажлын байр болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж сайжрах зэрэг үр дүн, эерэг хандлага бий болж байна.		
14	8.1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай	8.1.Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.	2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн дагуу Ерөнхий захирлын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/207 тоот тушаалаар Мэдээллийн ил тод байдлыг хангах журам, Байгууллагын гадаад, дотоод цахим хуудсанд ил тод нээлттэй мэдээлэх мэдээлэл, түүнийг хариуцах нэгжийн жагсаалтыг баталсан. Тус журмын хүрээнд Мэдээлэл технологийн албатай хамтран гадаад сайтын бүтэц мэдээллийг шинэчлэн журамд нийцүүлэн ажиллаж байна. Байгууллагын гадаад цахим хуудас болон Улсын Нэгдүгээр Төв эмнэлэг гэсэн фейсбүүк хуудсаар дамжуулан цаг тухай бүр нээлттэй мэдээллийг ил тод мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. 2023 оны эхний хагас жилд “УНТЭ”-ийн олон нийтийн цахим хуудсаар нийт 116 мэдээ, нийтлэл, ярилцлага тайлант хугацаанд нийтлэгдсэн байна. Цаг үеийн мэдээ-38 удаа Шууд дамжуулалт-1 удаа Гадаад хуудсаар-38 удаа 7 хоногийн тойм-11 удаа Видео-4 удаа Ярилцлага- зөвлөгөө-4 удаа	100%	Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллаж байна

				Нээлттэй сонгон шалгаруулалтын зар-13 удаа Авлигын эсрэг үйл ажиллагаа- Подкаст-1 Постер- 4 Шторк-2 гэх мэт нийтлэгдсэн байна.		
15	35.1	Архив албан хэрэг хөтлөлтийн тухай	35.1. Байгууллагын удирдлага албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, албан хэрэг хөтлөлтөд цахим тогтолцоог нэвтрүүлэх, холбогдох ажилтныг мэргэшүүлэх болон баримт бичгийг заавар, журам, стандартын дагуу зохион бүрдүүлж хөтлөх, тэдгээрийг хадгалах, ашиглах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавина. 35.2. Байгууллагын зохион байгуулалтын нэгж /газар, хэлтэс/-ийн дарга албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавина.	Албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж, албан хэрэг хөтлөлтөд цахим тогтолцоог нэвтрүүлж Эрүүл мэнийн салбарын хүрээнд able програм, байгууллага дотроо smart програмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Архивын ерөнхий газраас зохион байгуулж байгаа жил бүрийн сургалтад хамрагдаж байна. 2022 онд баримт бичгийн боловсруулалт, бүртгэл хяналтын журмыг батлуулж, заавар, журам, стандартын дагуу зохион бүрдүүлж хөтлөх, тэдгээрийг хадгалах, ашиглах үйл ажиллагааг хангаж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг хангуулж, 2022 онд баримт бичгийн боловсруулалт, бүртгэл хяналтын журмыг батлуулж Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжлийн Доктор профессор багшаар сургалт зохион байгуулсан. Цаасан болон цахим баримт бичгийн бүрдэлийг хийн ажиллаж байна.	100%	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

16	18	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	18 дугаар зүйл. Мэдээлэл хариуцагч 18.1.Мэдээлэл хариуцагч хуульд заасан үндэслэлээр, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглана. 8.2.Мэдээлэл хариуцагч мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах талаар дараах үүрэгтэй: 18.2.1.хуульд нийцүүлэн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах журам баталж, мөрдүүлэх;	УНТЭ-ийн Мэдээлэл, технологийн албанаас хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн талаарх мэдээллийг нийт эмч, сувилагч нарын хуралд тогтмол танилцуулан ажиллаж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хувь хүний эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн талаарх мэдээллийг хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн албан бичгийг үндэслэн болон эмч, эмнэлгийн мэргэжилтний хийж буй судалгаа шинжилгээний зорилгоор гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн ашиглаж байна. Мөн өвчний түүхийг цахим хэлбэрээр хөтлөх УНТЭ-ийн ерөнхий захирлын 2017 оны А/18 тоот журамд эмнэлгээр үйлчлүүлэгчийн түүхийг хэрхэн ашиглах талаар заалт байгаа хэдий ч түүнийг хуульд нийцүүлэн шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.	85%	Цахим өвчний түүх хөтлөх журмыг шинэчлэн батлуулахдаа Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн тусгай заалтыг оруулан батлуулах болон эмнэлгээр үйлчлүүлэгч-ээс зөвшөөрөл авах хуудсыг боловсруулан батлуулах шаардлагатай
17	19	Кибер аюулгүй байдлын тухай хууль	19 дүгээр зүйл.Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага 19.1. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагад дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага хамаарна: 19.1.3. хоёр, гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллага; Хуулийн 19.2-д заасан “Онц чухал мэдээллийн	Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Мэдээллийн аюулгүй байдлын газраар эрсдлийн үнэлгээг 2022 оны 11 сард хийлгэсэн бөгөөд уг үнэлгээний зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн байгууллагын гамшигийн үеийн төлөвлөгөөнд мэдээллийн аюулгүй байдал алдагдсан үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг болосвруулан батлуулсан. 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Мэдээллийн аюулгүй байдлын инженерээр Г.Гантулга инженер томилогдон ажиллаж нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад Кибер аюулгүй байдлын	90%	Мэдээллийн аюулгүй байдлын журмыг Кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж байна.

			дэд бүтэцтэй байгууллагын хүлээх үүрэг"-ийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа байдал	талаарх мэдлэг олгох сургалтыг тогтмол хийж ажиллаж байна. Сүлжээний гарц дээрх ГАЛТ ХАНА төхөөрөмжийг шинэчлэх худалдан авалтыг зохион байгуулж Тагнуулын ерөнхий газраар шалгуулж хүлээн аваад суурилуулсан.		
УИХ-ын тогтоол						
18		Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2022.11.11 №72	6/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, хөрөнгө оруулалт, татвар төлөлт, өр төлбөр, хүний нөөцийн мэдээллийг тухайн хуулийн этгээдийн цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулах;	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг tender.gov.mn, хөрөнгө оруулалт, татвар төлөлт, өр төлбөр мэдээллийг shilendans.gov.mn, хүний нөөцийн мэдээллийг тухайн хуулийн этгээдийн цахим хуудаст буюу unte.moh.gov.mn сайтад ил тод, нээлттэй байршуулан ажиллаж байна.	100%	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
19		Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;	УНТЭ нь албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтыг 2023 онд зохион байгуулаагүй байна.	100%	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
Засгийн газрын тогтоол						
20		2023-2024 оныг авлигатай тэмцэх жил	Улс төрд нөлөө бүхий этгээдийн хууль ёсны орлогоос давсан хэрэглээг таслан зогсоох, нийтийн албанд танилын хүрээгээр	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2023 оны ... тоот албан бичгээр өгсөн чиглэл, Эрүүл мэндийн сайдын 2023 оны ...тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу "Шүүр ажиллагаа"-ны хүрээнд Коронавируст		

		болгон зарлах тухай 2023.02.08 №49 тоот тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа”	томилогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх; ➤ авлига, албан тушаалын гэмт хэргийн хариуцлага гарцаагүй байх, холбогдсон этгээдийг нийтийн албанаас шүүрдэн цэвэрлэх; ➤ төрийн алба, төрийн өмчийг "шимэгчид"-ээс салгах; ➤ авлига, албан тушаалын гэмт хэргийг хуулийн хүрээнд бүрэн гүйцэд, шуурхай шалган шийдвэрлүүлэх. Тав. Шил ажиллагаа цахимжилтыг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хүнд суртлыг арилгах, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох	халдвар/Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүний нийгэм,эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсан 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс уг хууль хүчингүй болсон. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд тус эмнэлгийн сул орон тоонд удирдах албан тушаалтныг томилсон байдлын судалгааг гаргах ажлыг зохион байгуулж албан тушаалтны томилогдсон байдлын талаарх дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох бусад мэдээллийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж өгсөн чиглэлийг биелүүлж ажилласан. <u>Сонгон шалгаруулалт</u> Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ЗХНА-аас 2023 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн байдлаар эмнэлгийн гадаад цахим хуудасны “СУЛ ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ” дэд цэсэнд 22 ажлын байранд 36 удаа сонгон шалгаруулалтын зарыг боловсруулж ил тод, нээлттэй зарлан мэдээлсэн. УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба нь сул ажлын байрыг: ➤ Эрүүл мэндийн хөгжлийн төвийн - HR.HDC.GOV.MN сайт ➤ Монголын ажлын байрны төв сүлжээ - WWW.ZANGIA.MN сайт ➤ Эмнэлгийн гадаад цахим вэб хуудас - WWW.UNTE.MOH.GOV.MN сайт ➤ Хөдөлмөр халамж үйлчилгээний - WWW.EJOB.GOV.MN сайт ➤ Эмнэлгийн гадаад нээлттэй фэсебүүк сошиал маркетинг пэйж хуудас “УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ/THE FIRST CENTRAL HOSPITAL OF MONGOLIA”	100%	Эрх бүхий байгуулагаас өгсөн чиглэл,албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох мэдээллийг хүргүүлсэн
--	--	--	--	--	-------------	--

				➤ Эмнэлгийн хамт олны хаалттай фазебүүк групп ➤ Хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг ➤ Их Дээд сургуулиуд дээр зохион байгуулагддаг өдөрлөг дээр нээлттэй, ил тод зарлаж мэдээллэдэг. <u>Соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах чиглэлээр:</u> 1. Авлигатай тэмцэх газар, Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг хамтран 2023.05.30-ны өдөр “Хамтдаа хичээе-Бид чадна” хэлэлцүүлгийг нийт удирдах ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан. 2. Сүхбаатар дүүргийн прокурорын газар, Авлигатай тэмцэх газартай хамтран 2023.10.31-ний өдөр нийт сувилагч, тусгай мэргэжилтэнгүүдэд “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. 3. УИХ-аас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030) болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан төв байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-д зориулсан сургалтанд ЗХНА-ны дарга, ЭБАТ П.Мөнхтуул хамрагдсан.		
21		Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22		-УНТЭ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 05 дугаар 29-ний өдрийн 07 тоот тогтоолоор “УНТЭ-ийн дүрэм, бүтэц, орон тоо, стратеги төлөвлөгөө”-г баталсан. -УНТЭ нь дээрх бүтцийн дагуу албан тушаалын тодорхойлолтын загварыг УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2021.08.10-ны өдрийн А/178а тоот тушаалаар баталсан.	85%	Албан тушаалын тодорхойлолт шинэчлэх ажлууд хийгдэж байна

		Дугаар 2018_258	1.3.төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	-Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт, хөдөлмөр эрхлэлтийн үр ашигтай, зохистой харилцааг судлах зорилгоор ЭМЯ-аас баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу “Монголын ардын ухаан, арга билгийн төв”-ТББ-аас н.Отгондэлгэр, н.Батнасан зөвлөх нар нь УНТЭ дээр 2023.05.03-ны өдөр ажилласан бөгөөд бөгөөд байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, албан тушаалын тодорхойлолт зэрэг шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичгийг хуулбарлан өгч хамтарч ажилласан. -ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газарт албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг шинэчлэх ажил хийгдэж буйтай холбоотой УНТЭ-ээс 2023.05.19-ний өдрийн 1/779 тоот албан бичгээр УНТЭ-ийн албан тушаалын тодорхойлолтын жагсаалт болон 13 албан тушаалын тодорхойлолтын хуулбар хувийг цахимаар болон цаасан хувилбараар хүргүүлсэн.		
22		Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган	Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотой эмнэлгийн ерөнхий захирлын 2022.04.29-ний өдрийн А/135 тоот тушаалаар “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ”-г шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 13-р зүйлд “Хөдөлмөрийн сахилгын зөрчил, хариуцлага хүлээлгэх”, 14-р зүйл “Хөдөлмөрийн эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох, ажил хүлээлцүүлэх”, 15-р зүйл “Ажил олгогч ба ажилтны эрх үүрэг” хэсэгт хөдөлмөрийн харилцаанд хориглох заалтуудыг дэлгэрэнгүй тусгасан. Мөн Ерөнхий захирлын 2022.06.20-ны өдрийн А/199 тоот “Хөдөлмөрийн хугацаагүй гэрээний загварыг батлах тухай” тушаалаар батлан 2000	100%	Хориглох хэм хэмжээг дотоод журамд тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ төрлийн зөрчил гараагүй байна

			хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;	хувийг хэвлэн УНТЭ-ийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж байна. Ерөнхий захирлын 2022.10.20-ны өдрийн А/310 тоот “УНТЭ-ийн Хөдөлмөрийн хугацаатай гэрээний загваруудыг баталсан. Үүнд: Дагалдан ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, туршилтын хугацаагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, түр ажлын байранд ажиллуулах хөдөлмөрийн гэрээ Хөдөлмөрийн гэрээнүүдэд ажил олгогч ба ажилтны эрх үүрэг, хөдөлмөрийн гэрээг цуцлах, дуусгавар болгох үндэслэл, хөдөлмөрийн сахилгын шийтгэл, хариуцлага, хориглох зүйл, маргааш шийдвэрлэх зэрэг заалтуудыг дэлгэрэнгүй тусгасан.		
23		Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;	1.УНТЭ нь Нийслэлийн Сүхбаатар дүүргийн прокурорын газартай 2023.05.15-ны өдрөөс хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. 2.Уг гэрээний дагуу 2023.05.17-ны өдөр УНТЭ-ийн нийт эмч нарт зөрчлийн тухай хууль, эрхзүйн сургалтыг эмнэлгийн 4-р давхрын хурлын танхимд зохион байгуулсан. Сургалтыг Сүхбаатар дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Н.Дамбадаржаа Зөрчлийн тухай хуульд заасан Эрүүл мэндийн тухай хууль, тогтоомжийг зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал" сэдвээр; - Уг гэрээний дагуу 2023.05.26-ны өдөр УНТЭ-ийн дэмжих үйлчилгээний ажилтнуудад Сүхбаатар дүүргийн прокурорын газрын танхимд сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг Сүхбаатар дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Н.Дамбадаржаа Зөрчлийн тухай хуульд заасан “Эрүүл мэндийн тухай хууль, тогтоомжийг зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах	100%	Ажилтнуудыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулж байна

				асуудал" сэдвээр, хяналтын прокурор М.Гансувд “Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” сэдвээр тус тус сургалтыг амжилттай зохион байгуулсан. 3.УНТЭ-ийн ЁЗСХ-ны үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шилэн болгох ажлын хүрээнд УНТЭ-ийн гадаад сайт www.unte.moh.gov.mn сайтны ИЛ ТОД БАЙДАЛ буланд шинээр “Ёсзүйн салбар хороо” дэд цэсийг үүсгүүлж төлөвлөгөө, сургалтын тайлан, эмнэлгийн мэргэжилтэний ёсзүйн дүрэм, санал хүсэлт хүлээн авах албан тушаалтан түүнтэй холбогдох мэдээллийг тус тус байршуулж ажиллаж байна. 4.УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба болон УНТЭ-ийн дэргэдэх Ёсзүйн салбар хороо хамтран 2023 оны эхний 5 сард нийт 11 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулсан байна. Тайланг ЭМЯ-ны дэргэдэх Ёсзүйн хяналтын хороонд 2023.05.31-ний өдрийн 50/23 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЭМЯ-нд 203.05.31-ний өдрийн 1/854 тоот албан бичгээр хүргүүлсэн.		
24	1.9	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;	1. Цаг бүртгэлийг царайгаар таниулах системийг УНТЭ нь 2022.06.02-ны өдрөөс нэвтрүүлсэн. Уг цаг бүртгэлийн VertichERP системтэй холбон ажиллаж байна. 2. УНТЭ нь 2019.06.26-ны өдрөөс Интерактив ХХК-ийн VertichERP хүний нөөц, санхүү, цаг бүртгэл, програмыг ашиглаж байна. Уг програмын ашиглалтыг сайжруулах, хөгжүүлэлтийг хийлгэх зорилгоор системийн инженерүүдтэй 2023.05 сараас эхлэн хамтран ажиллаж байна.	100%	Хэрэгжүүлэн ажиллаж байна
				1. Эмнэлгийн ерөнхий захирлын 2022.07.28-ны А/246 тоот тушаалаар УНТЭ-ийн нийт ажилтнуудын "Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн	90%	

25	1.10	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;	дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журам"-ыг баталж мөрдөн ажиллаж байна. 2. Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотой эмнэлгийн ерөнхий захирлын 2022.04.29-ний өдрийн А/135 тоот тушаалаар “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ”-г шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 13-р зүйлд “Хөдөлмөрийн сахилгын зөрчил, хариуцлага хүлээлгэх”, 14-р зүйл “Хөдөлмөрийн эрхлэлтийн харицааг цуцлах, дуусгавар болгох, ажил хүлээлцүүлэх”, 15-р зүйл “Ажил олгогч ба ажилтны эрх үүрэг” хэсэгт хөдөлмөрийн харилцаанд хориглох заалтуудыг дэлгэрэнгүй тусгасан. 3. Мөн Ерөнхий захирлын 2022.06.20-ны өдрийн А/199 тоот “Хөдөлмөрийн хугацаагүй гэрээний загварыг батлах тухай” тушаалаар батлан 2000 хувийг хэвлэн УНТЭ-ийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж байна. 4. Ерөнхий захирлын 2022.10.20-ны өдрийн А/310 тоот “УНТЭ-ийн Хөдөлмөрийн хугацаатай гэрээний загваруудыг баталсан. Үүнд: Дагалдан ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, туршилтын хугацаагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, түр ажлын байранд ажиллуулах хөдөлмөрийн гэрээ 5. Хөдөлмөрийн гэрээнүүдэд ажил олгогч ба ажилтны эрх үүрэг, хөдөлмөрийн гэрээг цуцлах, дуусгавар болгох үндэслэл, хөдөлмөрийн сахилгын шийтгэл, хариуцлага, хориглох зүйл, маргааш шийдвэрлэх зэрэг заалтуудыг дэлгэрэнгүй тусгасан.	2023 онд УНТЭ-ийн дэргэдэх Ёсзүйн салбар хороонд 11 өргөдөл гомдол ирсэнээс 1 өргөдөл нь ажлын байран дахь дарамт шахалттай холбоотой байсныг шийдвэр лэсэн.
----	------	---	--	--	--

лл 26	120	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	3. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	1. УНТЭ-ийн дэргэдэх Ёсзүйн салбар хороо, Захиргаа нь мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилтнуудын ёсзүй, харилцаа, хандлага, хөдөлмөрийн сахилга батыг сайжруулах чиглэлд 2023 онд 34 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 2130 эмч, 1236 эмнэлгийн мэргэжилтэн, 624 дэмжих үйлчилгээний ажилтан хамрагдсан байна. 2. Захиргаа, хүний нөөцийн алба, Захирлын ажлын алба, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын албадууд хамтран амбулатори болон төв тасгуудад ажлын цаг ашиглалттай холбоотой гэнэтийн шалтгалтуудыг тухай бүрт гүйцэтгэж байна. 3. УНТЭ-ийн ерөнхий захирлын 2023.05.27-ны өдрийн А/59 тоот тушаалаар “Үйлчлүүлэгч төвтэй хүлээгдэл чирэгдэлгүй, хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг иргэдэд үзүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн үргүй зардлыг бууруулах, төлөвлөсөн орлогыг бүрдүүлэх, төвлөрүүлэх, түүнд хяналт тавих ажлыг зохион байгуулах” ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгээс Амбулаторийн тасгийн үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг сонсох, үйл ажиллагаанд хяналт тавих, ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилготой ажлын хуваарийг ерөнхий захирлаар батлуулан захиргааны тасгийн ажилтнууд 2023.03.07-2023.04.10 дуустал, 2023.04.12-2023.05.24 дуустал хугацаанд ажлын 55 өдрийн хяналтыг гүйцэтгэн, дэмжлэгт үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан.	100%	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна
----------	-----	---	---	---	------	---

27	122	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_203	1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон ороннутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн Хоёрдугаар бүлгийн дагуу 2023 онд УНТЭ нь тавилга, эд хогшил, бэлэг дурсгалын зүйл зүйл худалдан аваагүй, төсвийн хөрөнгөөр сургалт зохион байгуулаагүй байна.	100%	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна
----	-----	--	---	---	------	---

Хянасан:

Боловсруулсан:

1. *Бид/у/2*
 1. *Нихтүүл*

Ц. Амаржаргал ЗАА-ны дарга

Б.Энхтуул ЗАА-ны мэргэжилтэн